



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр сарын 16-ны
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 147

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5.1.3, 13.3-т тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2017 онд газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийн жагсаалт, нөөц бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл бүхий компаниудын нөөцийг 81 900 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэж бүрдүүлэх ажлыг 2017 оны 3 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 412 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд

Ц.ДАШДОРЖ